

**БАТЛАВ.
УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН**



Д.ЦОГТБААТАР

**ТАТВАРЫН МЭРГЭШСЭН ЗӨВЛӨХИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ” ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл, шаардлага

Татвар нь шударга ёсны илэрхийлэл, хүний эрх болон улс орны тусгаар тогтнолын баталгаа билээ. Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ нь татварын алба, татвар төлөгчийн гүүр нь тул бат бөх гүүр байж хүний эрх, шударга ёсныг хангах баталгаа юм. Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хууль нь 2012 оны 12-р сарын 27-нд батлагдан мөрдөгдөж буй энэ хугацаанд 3 удаа томоохон өөрчлөлт орсон байна. (Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын тухай хуулиудтай холбоотой, Зөрчлийн тухай хууль), Татварын хуулиудын шинэчлэл хийгдсэн өнөө үед Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ болон Татварын харилцааны хөгжил, өөрчлөлтийн нөхцөл байдал зэргээс Татварын мэргэшсэн зөвлөхийн үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол улсын үндсэн хууль болон бусад хууль тогтоомжтой нийцүүлэн боловсрууллаа.

Хуульд нэмэлт өөрчлөлт оруулах үзэл баримтлалыг дараах 3-н шаардлагад үндэслэв.

- Олон улсын болон Монгол улсын татварын тогтолцооны шинэчлэл, Татвараас зайлсхийх болон Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх зэрэг нийгэм, эдийн засгийн өөрчлөлттэй энэ хуулийн зохицуулалтыг нийцүүлэх

-Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тогтолцоо Монгол Улсад шинээр бий болж, хууль батлагдаад 10 жил болж байгаа тул зохицуулалт дутуу харилцааг тодорхой болгох. Ялангуяа зөвлөхийн татварын мэргэшсэн зөвлөхийн эрх авсан боловч хуулийн этгээдэд харьяалагдахгүй байгаа зөвлөхийн харилцаа хуульд тусгагдаагүй байсныг тодорхой болгож зохицуулах

-Татварын хуулиуд шинэчлэгдсэнтэй холбоотой, татвар төлөгчдийн эрх ашиг хамгаалагдах, эрсдлээс сэргийлэх орчинг бүрдүүлэхэд зөвлөх үйлчилгээний хүрээ, зохион байгуулалтыг илүү тодорхой болгох

Одоо мөрдөгдөж буй Татварын зөвлөх үйлчилгээний тухай хуулиар Монгол улсын Үндсэн хуулийн 17.1.3-р заалт, Татварын ерөнхий хууль/Шинэчилсэн найруулга/-ийн 6.1.12, 12.1.5, 12.1.10, 29.6, 41.12.1, 47.1, 75.5, 77.7.11, 75.4(75.4.Татвар төлөгч нь татварын хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэх, эрхээ эдлэх талаар хуулиар зөвшөөрөгдсөн татварын мэргэшсэн зөвлөхийн туслалцаа, зөвлөгөө авах эрхтэй) зэрэг заалтуудын хэрэгжилтийг хангах орчин тодорхой хэмжээнд бүрдүүлсэн гэж үзэж болох хэдий ч татварын хуулиудын зарим зүйл заалтуудыг хэрэгжүүлэх механизм, хэрэгжилтэд тавигдах хяналт, зохицуулалт өнөөг хүртэл маш сул байсаар байна. Тухайлбал, өнөөгийн манай татварын системийн хөгжил, зарчмуудыг тодорхойлсон

гол заалтуудаас Татварын ерөнхий хууль/Шинэчилсэн найруулга/-ийн дараах бүлэг, заалтын практик хэрэгжилт хангалтгүй, төрийн зүгээс хэрэгжилтэд нь хангалттай хяналт тавьж чадахгүй л байна. Үүнд:

- Зургаадугаар бүлэг. Татвар төлөгчийг бүртгэх, татвар ногдуулах, төлөх, тайлагнах (*татварын төлөгчийн үүрэг*);

- 76 дугаар зүйлийн 76.9 дэх хэсэгт Татварын улсын байцаагч, хураагч нь хувийн зорилгоор татвар төлөгчтэй холбогдож түүнд аливаа хэлбэрээр зөвлөгөө өгөх, нягтлан бодох бүртгэл хөтлөх, тайланг гаргах, аудит хийх, татвараас зайлсхийхэд туслах, шаардахыг хориглоно. (*татварын улсын байцаагчид хориглох зүйл*).

Татварын хуулиудын хэрэгжилтийг хангахад татварын мэргэшсэн зөвлөхийн үйл ажиллагааны туслалцааг авах эрх зүйн орчны суурь тавигдсан ч зарим зохицуулалтгүй байдал нь татвараа өөрөө тодорхойлон төлөх, хуулийг сахин мөрдөх үүргийн хэрэгжилт, татвар хураалт, хяналтын оновчтой орчин бүрдүүлэхэд сөрөг нөлөө үзүүлж байна. Зөвхөн ХХОАТ-ын хуулийн хувьд нийт тайлангаа ирүүлбэл зохих иргэдээс ихэвчлэн хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдах иргэд тайлан ирүүлдэг, нийт орлогын 90 орчим хувь нь суутгаснаар бүрдэж буй байдлаас татвараа өөрөө тодорхойлон төлөх тогтолцооны бодит байдал харагдана. Энэхүү хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээг нийгмийн хэрэглээ болгох нь татварын механизмаар нийгэм, эдийн засгийн олон чухал асуудлыг шийдвэрлэх болно.

Татвар төлөгч хууль ёсны хүрээнд эрх ашгаа хамгаалах нь хүний эрхийн асуудал тул тэдэнд татварын хууль тогтоомжийг сайн дураар даган мөрдөх дадлыг төлөвшүүлэх, нийгмийн сэтгэл зүйг бүрдүүлэх, татвар төлөх үндсэн үүргээ /*Үндсэн хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3*/ хэрэгжүүлэхэд нь туслалцаа үзүүлэх, татварын нарийн мэргэшсэн мэргэжилтэн төрийн бодлоготойгоор ашиглах нь татвар төлөгч, татварын албаны харилцаанд шударга, тэгш, үр ашигтай байх зарчмын мөрдөлт, татварын сайн засаглал бүхий орчин нөхцөл бүрддэг гэдгийг Олон улсын туршлагаар нэгэнт нотлогдсон.

Татварын хуулиудын шинэчлэл хийгдсэнээр үнэ шилжилтийн тайлан, жижиг дунд бизнес эрхлэгч, орлого олж буй хувь хүмүүс татварын хуулийг сахин мөрдөх үүргээ хэрэгжүүлэх хариуцлагатай тогтолцоо болоход татвар мэргэшсэн зөвлөхийн үүрэг их юм.

Татвараа ногдуулан төлөх үүргээ хэрэгжүүлж буй өнөөгийн байдлаас харахад энэхүү үүргийг ТМЗ нийгэмлэгээс бэлтгэгдэж, тусгай зөвшөөрөл авсан татварын итгэмжлэгдсэн хуулийн этгээд албан ёсоор хэрэгжүүлэхийн зэрэгцээ албан бусаар хэн дуртай нь энэ үйлчилгээг үзүүлж байгаа нь уг үйлчилгээний утга учир, мөн чанарыг алдагдуулж байгаа төдийгүй нийгэмд татвар төлөгчийн үүргээ хэрэгжүүлэх, өөрөө тайлагнах тогтолцоог үнэгүйдүүлж, хууль хэрэгжүүлэх үүргийг гажуудуулж, үүнээс үүсэх эрсдэлийг хариуцах эзэнгүй тогтолцоо үргэлжилсээр ирсэн. Энэ нь татварыг ил тод болгох, өршөөл үзүүлэх арга хэмжээ авахад хүргэдэг, энэ нь эргээд шударгаар хуулиа даган мөрддөг татвар төлөгчдийг бухимдуулах, ёс бус байдал руу оруулах сөрөг талтай. 2015 онд ил тодын хуулиар 34,7 тэрбум төгрөгийн орлогыг тайлагнасан нь зөвхөн татварын алба нуугдмал орлогыг илрүүлэх боломжгүй буюу хууль зөрчснийг тогтоох чадваргүй тогтолцооны үр дүн болохыг илэрхийлнэ.

Жижиг, бичил сегмент, ялангуяа орон нутагт татвар төлөгчид хууль ёсны эрх хамгаалах, татварын төлөх үүргээ биелүүлэхэд мэргэжлийн туслалцаа авах эрхээ хангах зохицуулалт өнөөгийн хуульд дутагдалтай байгаа нь хүний эрхэд халтай болох нь практикаас тодорхой байна.

Хуульд нэмэлт өөрчлөлт оруулах үзэл баримтлал нь татварын хуулийг хэрэгжүүлэхэд эрх бүхий мэргэшсэн мэргэжилтний туслалцаатайгаар хэрэгжүүлэх хариуцлагатай тогтолцоо болгох, төвлөрлийг сааруулах талаарх төрийн зүгээс баримтлах бодлого, Засгийн газрын мөрийн хөтөлбөр, Олон улсын татварын болон Татварын хуулиудын шинэчлэлийн үзэл баримтлалтай нийцүүлж Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар татварын тогтолцооны шинэчлэлийг бүрэн утгаар нь төгөлдөршүүлэхэд тустай юм. Энэ нь хүний эрхийг хамгаалах, нийгмийн шударга ёсны харилцааны цөм механизм нь билээ.

Хоёр.Хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийн зорилго,ерөнхий бүтэц,зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт өөрчлөлтийн төсөлд *нэгдүгээрт* нэмэхээр 17 зүйл туссан ба энэхүү нэмэх зүйлсийн хүрээ нь татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний хүрээг өргөтгөх, зохион байгуулалтад нөхөрлөл ба хувь хүний харилцааны зохицуулалтуудыг нэмсэн. *Хоёрдугаарт* өөрчлөн, найруулах 18 зүйл туссан ба үйлчлүүлэгч, татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээг эрхлэх этгээд, татварын мэргэшсэн зөвлөх зэрэг нэр томъёо, зөвлөх үйлчилгээний ойлголт, тавигдах шаардлага зэрэгт өнөөгийн практикаас үүдэлтэй зохицуулалтуудыг оруулсан. *Гуравдугаарт* өөрчлөх 11 зүйлд Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу орсон өөрчлөлттэй холбоотой нэр томъёоны залруулга болгон итгэмжлэгдсэн гэсэн үгийг мэргэшсэн зөвлөх гэдгээр өөрчилсөн болно. *Дөрөвдүгээрт* хүчингүй болгох 1 зүйл туссан болно

Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд татварын мэргэшсэн зөвлөх хувь хүнд татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ эрхлэх харилцааг зохицуулах, татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тавигдах шаардлагыг уян хатан болгох, татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ эрхлэх этгээдэд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, татварын мэргэшсэн үйлчилгээтэй холбоотой бусад зохицуулалтын асуудлыг тодорхой болгож тусгасан.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, хүрэх үр дүн, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай санал

Татварын мэргэшсэн зөвлөхийн тогтолцоо нь татвар төлөгчдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, татварын мэдлэг олгох орчин бүрдүүлснээр татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх төрийн үйлчилгээг хөнгөвчлөх, төсвийн татварын орлогыг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ.

Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний хуульд нэмэлт өөрчлөлт оруулах төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засгийн дараах эерэг үр дагаврыг бий болно. Үүнд:

Төр болон татварын албанд:

- Татвараа сайн дураараа өөрөө тодорхойлон төлөх дадлыг төлөвшүүлэх төдийгүй татвар төлөлт, тайлагналын хариуцлагатай тогтолцоо болно
- Эрх бүхий татварын мэргэшсэн зөвлөхийн оролцоотойгоор татварын хуулийг сахин мөрдөх хариуцлагатай орчин бүрдүүлэх
- Татварын мэргэшсэн зөвлөх нь – эрх бүхий ТИХЭ, хувь хүн үзүүлэх бизнесийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалттай болох
- Татварын алба татварын мэргэшсэн зөвлөхөөр тайлан, мэдүүлгийг үйлдүүлснээр хуулийн хэрэгжилт, тайлангийн үнэ зөв байдал сайжрах, харин татварын алба хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөл бүрдэх (татварын байцаагчдын 20-30% хураалтад, 70-80% нь хяналтад ажиллах орчин бүрдэх).
- Татварын алба тайлагналыг үйлдсэн этгээдтэй нь хариуцлага хүлээлгэдэг тогтолцоог бий болгосноор одоогийн Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуулийн 7.1.5-р заалт хэрэгжих нөхцөл бүрдэнэ
- ТМЗ-ийн үүргийг нэмэгдүүлэх замаар төрийн татварын хуулиудын хэрэгжилт болон татвар хураалтыг сайжруулах, төсвийн татварын орлогыг нэмэгдүүлэх боломж бүрдэх.
- Татварын чиглэлийн маргаан, шүүх үйл ажиллагаанд тусгай сургалтад хамрагдаж зохих шалгуурыг хангасан эрх бүхий өмгөөлөгч, хуульчдыг итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцуулах нөхцөл бүрдэх

Татвар төлөгчийн хүрээнд:

- Эрх бүхий этгээдээр хууль ёсны эрх ашгаа хамгаалуулах, хариуцлагатай тогтолцоог бий болох
- Мэргэшсэн мэргэжилтнээр эрх ашгаа хамгаалуулснаар татварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх

Татвар төлөх үүргийн хэрэгжилтээ эрх бүхий мэргэшсэн зөвлөхөөр гүйцэтгүүлснээр бизнесийн хөгжилд баталгаа болох

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай уялдсан байдал, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаарх санал

Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль нь Монгол улсын үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид нийцэж байгаа бөгөөд тус хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл байхгүй болно.

--ooOoo--